



БАТЛАВ:
ЗАСАГ ДАРГА

Б.ЭРДЭНЭБААТАР

ХЭНТИЙ АЙМГИЙН ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ХАРЬЯАТ ДЭЛХИЙН АВАРГЫН
ДӨРӨВДҮГЭЭР БАЙРЫН ШАГНАЛТ, АЗИ ТИВИЙН АВАРГЫН ХОШОЙ МӨНГӨ
ХҮРЭЛ МЕДАЛЬТ, ХЭТ ХОЛЫН МАРАФОН ГҮЙЛТИЙН ОУХМ
Д.АРИУНЖАРГАЛЫН НЭРЭМЖИТ “АЙРАГИЙН ЭНГЭР-2024”
КРОСС ГҮЙЛТИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ

2024.09.17

Айрагийн энгэр

Нэг.Зорилго

Хүн амын дунд нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэн сурталчилах, гүйлт, чийрэгжүүлэлтийн үйл ажиллагааг тогтолжуулах, хөдөлгөөний хомсдолоос урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийг дэмжих, эх орондоо гүйлтийн спортыг аймаг бүрт сурталчилан таниулж хөгжүүлэх, өсвөр үе болон насанд хүрэгчдийн тэсвэр хатуужил, өөрийн дотоод нөөц боломжкоо нэмэгдүүлэх, бие бялдрын болон оюун санааны өв тэгш байдлыг төлөвшүүлэхэд оршино.

Хамрах хүрээ: Хэнтий аймгийн иргэдийн дунд

Хоёр.Ерөнхий зохион байгуулагч

- Монголын хэт холын марафон гүйлтийн холбоо

Ивээн тэтгэгч:

Хамтран зохион байгуулагч:

- Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
- Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын Засаг даргын Тамгын Газар
- Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын Ерөнхий боловсролын сургууль
- 1991, 1993 оны Өмнөдэлгэр сумын 10 жилийн сургуулийн төгсөгч нар
- Хэнтий аймгийн Биеийн тамир, спортын газар
- Хэвлэл мэдээлэл: MNB, Нийслэл ТВ

Гурав. Тэмцээнийг явуулах хугацаа, зохион байгуулах журам

Тэмцээн 2024 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн Бямба гарарт Хэнтий аймгийн Өмнөдэлгэр суманд зохион байгуулагдана.

08:00-09:30 Тамирчдын эцсийн бүртгэл, шалгах

10:00-10:25 Нээлтийн ажиллагаа /Өмнөдэлгэр/

10:25-10:50 Тамирчдын бие халаалт

11:00 Гараа

14:00-14:30 Хаалтын ажиллагаа /Соёлын төвд/

Тэмцээний зай, ангилал

Тэмцээн 1: Өсвөр үе:

Ерөнхий боловсролын сургуулиудын дунд кросс гүйлт 5 насны ангиллаар /засмал болон шулуун замаар/

№	Төрөл	Насны ангилал		Хүйс
1	500м	7-9	2015-2017	Охид, хөвгүүд
2	1000м	10-11	2013-2014	Охид, хөвгүүд
3	2000м	12-13	2011-2012	Охид, хөвгүүд
4	3000м	14-15	2009-2010	Охид, хөвгүүд
5	4000м	16-17	2007-2008	Охид, хөвгүүд

Жич: Өсвөр үеийн тамирчид нэг зай, төрөлд хэдэн ч тамирчин оролцож болно.

Тэмцээн 2: Насанд хүрэгчид:

Кросс гүйлт /5 насны ангилалд/

№	Төрөл	Насны ангилал		Хүйс
1	5000м	18-29	2006-1995	Эр, Эм
2	4000м	30-39	1994-1985	Эр, Эм
3	3000м	40-49	1984-1975	Эр, Эм
4	2000м	50-59	1974-1965	Эр, Эм
5	1000м	60-с дээш	1964 он	Эр, Эм

Дөрөв.Шагнал урамшуулал

Эхний 3 байрт орсон өсвөр үе, насанд хүрэгчдийг алт, мөнгө, хүрэл медаль, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнана.

Багаа амжилттай зохион байгуулж, багаараа тэргүүн байр эзэлсэн сумыг шилжин явах цом, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнана.

Тав.Байгууллагын дүнг гаргах

Тэмцээн 1: Өсвөр үе:

- 5 насны ангилалд эхний байруудад шалгарсан /охид-1, Хөвгүүд-1/ тамирчны оноог багийн дүнд оруулж тооцно.
- Зөвхөн Хэнтий аймгийн иргэний харьялалтай баг, сум, сургуулийн хүүхдүүд хамрагдана.
- Хэрэв нээлттэй зохион байгуулагдвал тухайн үед зарлагдана.

Тэмцээн 2: Насанд хүрэгчид:

- Тэмцээнд нэг байгууллагаас хэдэн ч баг, тамирчид оролцож болно.
- 5 насны ангилалд эхний дээд амжилт үзүүлсэн эр-1, эм-1 тамирчин, багийн оноонд оруулж байгууллагын дүнг гаргана.

Зургаа.Техникийн зөвлөгөөн

- Өмнөдэлгэр сумын Соёлын төвд 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 18:00 цагаас техникийн зөвлөгөөн болно.
- Зөвхөн баг хариуцсан дасгалжуулагч хамрагдана.

Долоо.Мандат, энгэрийн номер олгох

Байгууллага болон сургуулийн эмчийн мэдүүлэг /компьютерээр шивсэн байх/

Өсвөр үе:

- Төрсний гэрчилгээ
- Сурагчийн хувийн хэрэг
- 3x4 зураг 1% /сүүлийн 3 сарын дотор авахуулсан/

Насанд хүрэгчид:

- Иргэний үнэмлэх, гадаад паспорт, цэргийн үнэмлэх шалгаж олгоно.
- 4x6 зураг 1% /сүүлийн 3 сарын дотор авахуулсан/

-Хаягийн зөрчилтэй мэдүүлгийг хүлээн авахгүй. /зөвхөн Хэнтий аймгийн иргэдийн дунд зохион байгуулж байгаа тул/

Аймаг, сумдын тамирчдын энгэрийн номер, мандатыг 2024.10.18-ны өдрийн 09:00-22:00 цагийн хооронд Өмнөдэлгэр сумын Соёлын төвд бүртгэл хийж олгоно. Тэмцээний өдөр мандат, энгэрийн дугаар олгохгүй.

/Жич: Энгэрийн номер, мандат өсвөр нас 5000 төгрөг, насанд хурэгчид 10000 төгрөг төлж тэмцээнд оролцох эрх нээгдэнэ./

Оролцох байгууллага нь баг тамирчдынхаа урьдчилсан тоон мэдүүлгийг байгууллагын цахим хаягаар тэмцээн болохоос 20, эцсийн нэрийн мэдүүлгийн тэмцээн болохоос 7 хоногийн өмнө багтаан компьютерээр шивж, хүн бүрийн овог нэр, регистрийн дугаар, цусны бүлэг, утас, дасгалжуулагч, эмчийн гарын үсэг баталгаажуулан хавсралтад буй маягтын дагуу бөглөн info@mumf.org.mn, umnuudelgerzdtg2022@gmail.com хаягуудаар орж бүртгүүлнэ. Заасан хугацаанаас хоцорсон тохиолдолд бүртгэлийг хүлээн авахгүй.

Тамирчид санал гомдол гаргасан тохиолдолд өрөнхий шүүгч мандат, иргэний үнэмлэхний тулгалтыг тэмцээний аль ч үед хийж, маргааныг таслах эрхтэй.

Найм. Санамж

Нээлтийн ажиллагаанд байгууллагынхаа туг, хаягтай жагсаж, оролцох баг тамирчид бүгд ижил өнгийн футволка дээр энгэрийн номерыг урд нь тогтоож, спортын зориулалтын пүүз, хувцастай оролцоно.

- Энгэрийн дугаар, мандат аваагүй тамирчдыг тэмцээнд оролцуулахгүй.
- Мэдүүлэг өгөөгүй байгууллага, хувь хүнийг тэмцээнд оролцуулахгүй. Мөн гараар бичсэн мэдүүлгийг хүлээн авахгүй, заавал эрүүл гэсэн эмчийн тамгатай байна.
- Цаг агаарын нөхцөл байдлаас шалтгаалж, тэмцээний хугацаа хойшлогдох тохиолдолд тухайн өөрчлөлтийн талаар техникийн зөвлөгөөн дээр ярилцана.
- Тэмцээний явцад уулзвар, салаа, жим дээр онцгойлон таних тэмдэг улаан туг, алаг дарцаг, тууз байршуулна.
- Хөдөө орон нутаг, sumaas оролцож байгаа тамирчдын байр, хоол, ирэх, буцах унааны зардлыг тэмцээнд оролцуулж буй байгууллага хариуцна.
- Энгэрийн дугаарыг тэмцээн зохион байгууллагч байгууллага олгоно.

- Гүйх чиглэл, маршрутын дэлгэрэнгүй мэдээллийг мандат олгох өдөр багийн ахлагч наарт өгнө.
- Тэмцээний үед эмч шүүгч, гүйгчдэд эмнэлгийн анхан шатны тусlamж үзүүлэх, онцгой аюултай зүйл тохиолдвол гүйгчийг замаас гаргаж, гүйлтийг шууд зогсоох эрхтэй.

Ec.Гүйгчдийн хүлээх үүрэг

- Товлосон хугацаанд урьдчилан бүртгэлд бүртгүүлсэн байна.
- Гүйгчид нь гүйлтийн явцад өөрийн эрүүл мэндийг бүрэн хариуцах үүрэгтэй бөгөөд ямар нэг хүндрэл бэрхшээл гарвал эмчид даруй мэдэгдэх ёстай.
- Зам товчлохгүй, шүүгчдийг будилуулахгүй байх, тэмцээнд шударга оролцно.
- Нас дарж тэмцээнд оролцохыг хориглоно.

Дэлгэрэнгүй мэдээллийг:

Web site: www.sport.gov.mn/ultramarathon

Facebook: Mongolian Ultra Marathon

E-mail: info@mumf.org.mn

Хаяг: ХУД, Монголын Үндэсний Олимпийн хороо, 110 тоот

Утас: 99995586, 95959809, 70009809, /МХХМГХолбоо/
89707510, 99694724 ОУХМ Д.Ариунжаргал